



## БАТЛАН ХАМГААЛАХЫН ТӨВ АРХИВ 82 НАС ХҮРЛЭЭ

Монгол Улсын архивын сан хөмрөгийн салшгүй нэг хэсэг болсон Батлан хамгаалахын Төв архив 82 нас хүрлээ. Тус архив нь Халхын голын дайны гал дүрэлзэж байсан тэртээ 1939 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжны орлогч, корпус командлан захирагч Ц.Лувсандондойн гарын үсэг бүхий "Цэргийн яам ба Улс төрийн газрын бүх хуучин оны бичиг хэргийг эмхтгэн цэгцлэх ба архивыг байгуулах тухай" 40 дүгээр тушаал гарснаар үүсэн байгуулагдаж, эдүгээ 82 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Уг архивд БХЯ, ЗХЖШ, харьяа анги, байгууллагуудын үйл ажиллагааны явцад бий болсон 1921 оноос өнөөг хүртэлх түүх, эрдэм шинжилгээ, лавлагаа, мэдээллийн ач холбогдол бүхий байнга болон түр хадгалагдах баримт бичгүүд хадгалагдан ашиглагддаг.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас холбогдох албан байгууллагуудын үйл ажиллагааг тусгай горимд шилжүүлэн ажиллуулж байгаа энэ цаг үед иргэд, албан байгууллагын



эрэлт, хүсэлтийн дагуу лавлагаа, мэдээллээр үйлчлэх үйлчилгээгээ тасралтгүй явуулж байна. Салбарын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан нийт бие бүрэлдэхүүнд Батлан хамгаалахын Төв архив үүсэн байгуулагдсаны ойн мэндийг дэвшүүлж, Монгол Улсын БХЯ, Зэвсэгт хүчний юугаар ч орлуулшгүй үнэт өв болсон архивын баримтын сан хөмрөгийг баяжуулан, хойч үедээ өвлүүлэн үлдээх их үйлсэд нь өндөр амжилтыг хүсэн ерөөе. Амьдрал өөрөө ус мэт урсан өнгөрч, архив уул мэт сүндэрлэн үлддэг.

## РОТЫН ТАКТИКИЙН БҮЛЭГ ҮҮРГЭЭ АМЖИЛТАЙ ГҮЙЦЭТГЭЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын UNMISS энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй хурандаа Д.Энхбаатар захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн 106 хоногийн хугацаанд цэргийн багийн хариуцлагын бүс Маёом сууринд ажиллагааны түр бааз байгуулан үүргээ амжилттай гүйцэтгэж байнгын байрлалдаа

хамгаалалтын үүрэг болон иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор "Юнити" секторын командлагчийн захирамжийн дагуу түр ажиллагааны баазыг байгуулан холын эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн юм. Холын эргүүлийн бүлэгт 150 гаруй алба хаагч, 15 нэгж техниктэйгээр 3 ээлжээр үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Маёом суурингаас зам маршрутын дагуу нийт 22 чиглэлд 96 удаагийн

болгосон байна. Иргэн-цэргийн харилцааг хөгжүүлэх ажлын хүрээнд Маёом суурингийн эмнэлэгт нэн шаардлагатай эм тариа, ороох боох материал хандивласны зэрэгцээ сургуулийн насны хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл, тоглоом, амны хаалт зэргийг бэлэглэсэн юм.

Батальоноос томилогдсон ротын тактикийн бүлгийн үүрэг гүйцэтгэлт, цагийн байдалтай газар орон дээр нь танилцахаар UNMISS



ирлээ. Тодруулбал, 120 мянган хүн амтай Маёом сууринд өнгөрсөн оны үерийн гамшиг, хүнсний хомстлоос үүдэлтэй малын хулгай дээрэм, өс хонзонгийн сэдэлтэй омог хоорондын мөргөлдөөн, зэвсэгт бүлгүүдийн халдлага, дайралт идэвхжсэний улмаас тус бүс нутагт цагийн байдлыг тогтворжуулах, энгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах, НҮБ-ын эргүүл, цувааны

хол, ойрын эргүүлээр 10700 км замыг туулжээ. Үүрэг гүйцэтгэх хугацаанд НҮБ-ын гэрээт жолооч Кени Улсын барьцаалагдсан хоёр ажилтныг аварч, халдлагад өртсөн орон нутгийн 27 иргэнд эмнэлгийн тусламж үзүүлэн Манкиен суурин дахь хүмүүнлэгийн эмнэлэг рүү татан гаргаж, Маёом суурингийн төвд тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгслийг илрүүлэн аюулгүй

энхийг дэмжих ажиллагааны хүчний командлагч, "Юнити" секторын командлагч болон албаны бусад төлөөлөгчид түр ажиллагааны баазад ажлын айлчлал хийж, томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт, орон нутгийн иргэдтэй явуулж байгаа хүмүүнлэгийн ажиллагааг үзэж танилцаад, өндөрөөр үнэлэв.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАМИД

## САЛАА, САЛБАРЫН ЗАХИРАГЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЯВУУЛЛАА

### Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Ангийн захирагчийн тушаалаар салаа, салбарын захирагч нарын зөвлөгөөнийг "Зөв төлөвшил, зөв хүмүүжил" сэдвээр зохион явууллаа. Зөвлөгөөнийг салаа, салбарын офицеруудын цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдан явуулах заах арга зүйг сайжруулах, цэргийн дүрмийн дагуу цэргийн алба хаагчидтай харьцах, өөрийн удирдлагад байгаа захирагдагчдаа сурган хүмүүжүүлж, эх оронч, үндэсний үзэлтэй зөв иргэн хүн болгон төлөвшүүлэх зорилгоор явуулав. ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар, Тусгай хүчний цэргийн командлалын штабын дарга, бригадын генерал Л.Гансэлэм нар зөвлөгөөнд оролцож буй алба хаагчидтай цахимаар холбогдож, үүрэг чиглэл өглөө. Уг зөвлөгөөнд салаа, салбарын нийт 25 офицер хамрагдаж, халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиж хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан юм. Мөн зөвлөгөөнд урилгаар ҮБХИС, Аюулгүй байдлыг хангах сургуулийн Эдийн засаг, менежментийн тэнхимийн багш нар, "Гэгээн үйлс" хууль зүйн товчоо, "Цаглашгүй мэдлэг" ТББ-ын төлөөлөл оролцов. Хөтөлбөрийн хүрээнд Захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа Ц.Эрдэнэбаяр "Монгол бахархал-Монгол хүн байхын учир" сэдвээр лекц, Захирагчийн орлогч, захирагчийн удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа Б.Чинзориг "Тасаг, бүлгийн дарга нарыг сурган хүмүүжүүлэх арга зүй, хүнтэй ажиллах арга барил эзэмших нь" сэдвээр хичээл заасан бол Захирагчийн зэвсэглэл, техник хариуцсан орлогч, дэд хурандаа А.Баясгалан "Зэвсэглэл, цэргийн техникийн арчлан хамгаалалт, үзлэг явуулах журам", Захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч,



дэд хурандаа М.Энх-Амар "Цэргийн алба хаагчийн хувцас, хүнсний нормт хангалт" сэдвээр тус тус сургалт явууллаа. Түүнчлэн ҮБХИС, Аюулгүй байдлын сургуулийн Эдийн засаг менежментийн тэнхимийн багш, доктор Г.Оюунтуяа, С.Галсандаш нар "Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүд, тэдгээрийг бууруулах арга зам", "Нийгмийн харилцаа ба Цэргийн алба хаагчийн ёс зүй" сэдвээр сургалт явуулж, цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, хоорондын харилцаа, нийгэм ба цэрэг-иргэний хоорондын харилцааны талаар "Заавар, шийдэл, оюуны зураглал, хэлэлцүүлэг" үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэг явуулсан юм. Зөвлөгөөний төгсгөлд ангийн захирагч, хурандаа Ж.Сүх-Очир офицеруудад хандаж "Цэргийн хүний үндсэн хөдөлмөр бол сургалт бэлтгэл юм. Та хэрхэн ажиллаж байна, таны цэргүүд таны арга барилаар ажиллах болно. Цаашдаа та бүхэн хариуцаж байгаа ажил алба, эзэмших зэвсэг техниктээ эзэн нь болж, алба хаагчдаа хүний ёсоор хайрлаж, цэргийн ёсоор захирах нь чухал юм" хэмээн онцлов.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ

## ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ШИЛДЭГ АРГА БОЛ ШУДАРГА ШИЙТГЭЛ ЮМ



Агаарын цэргийн командлалын Захирагчийн удирдлагын хэлтсээс Агаарын цэргийн анги, салбаруудын захирагч, удирдах албан тушаалтнуудтай "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шилдэг арга бол шударга шийтгэл юм" сэдэвт цахим сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулав. Тус сургалт, зөвлөгөөнийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Захирагчийн удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Б.Баярсайхан нээв. Тэрээр энэ цаг үед захирагч, дарга нар хууль, эрх зүйн мэдлэггүйгээр хамт олноо удирдан чиглүүлэхэд учир дутагдалтай болсныг онцлон дурдаад зөвлөгөөндөө идэвхтэй оролцохыг уриалж, сургалтад амжилт хүслээ. Энэ үеэр Агаарын цэргийн командлалын хуулийн офицер, хошууч Б.Цолмонсүрэн "Тушаал, шийдвэр боловсруулах арга зүй", 065 дугаар ангийн хуулийн офицер, ахмад Л.Ганчимэг "Захирагчийн ерөнхий хуулийн эс үйлдэхүй, түүнээс гарах сөрөг үр дагавар", 353 дугаар ангийн хуулийн офицер, ахмад Б.Түвшинтөгс "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл, арга зам", 337 дугаар ангийн хуулийн офицер, дэслэгч

Т.Энхтуул "Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэглээ" зэрэг сэдвээр сургалт явууллаа. Мөн анги, салбаруудын захирагч, удирдах албан тушаалтнууд захирагчийн удирдлагыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа хууль, эрх зүйн асуудлыг хэлэлцэн эрх зүйн зөвлөгөө, хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулав. Сургалтын төгсгөлд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Б.Энхзоргол анги, салбаруудын захирагч, удирдах албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгч, ажил албандаа хариуцлагатай хандахыг сануулсан юм. Энэхүү сургалт, зөвлөгөө нь Агаарын цэргийн анги, салбаруудын захирагч, удирдах албан тушаалтнуудад хууль, эрх зүйн мэдлэг олгож, мэдээллээр хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тушаал шийдвэр боловсруулахад хууль тогтоомжийг зөв хэрэглэхэд сургахаас гадна тускомандлалын хүрээнд гэмт хэрэг, сахилга дэг журмыг чангатгах, орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зорилгоор явагдсан юм.